



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2010 ОНЫ ОНЦЛОХ 10 БҮТЭЭЛЧ АЖИЛ

2011.05.20

1. ИРГЭД, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ, ЧӨЛӨӨТ ЦАГТ ЗОРИУЛСАН ТАВ ТУХТАЙ АМЬДРАХ ОРЧИН БҮРДҮҮЛЖ БАЙНА.



1.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 640 хүний суудалтай Спортын ордонг шинээр ашиглалтанд оруулав.

Арвайхээр хотод улсын болон орон нутгийн төсвөөс 21.8 тэр бум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 640 хүний суудалтай Спортын ордныг ашиглалтад оруулж, Хүүхэд, залуучуудын парк, цэцэрлэгт хүрээлэн, 150 ортой хүүхдийн цэцэрлэг, автозам, зочид буудал зэргийг шинээр байгуулж, мод, зүлэг суулгах ажлыг мэргэжлийн байгууллага Улаанбаатар хотын “Цэцэрлэгжилт” компаниар

гүйцэтгүүлэв.

Аймгийн хүүхдийн урлагийн наадмыг зохион байгуулж, ХДТеатр, “Хүүхдийн төлөө хэлтэс”-ийн дэргэдэх “Ирмүүн” бүжгийн хамтлагийг өргөтгөн хүүхдийн “Суварга” чуулга байгуулан “Сэтгэлийн домог” дуулалт жүжиг бэлтгэн аймагтаа болон нийслэлд тоглолт зохиов. “Миний нутаг сайхан” сэдэвт сум сурталчлах урлаг, спортын өдөрлөгийг Арвайхээрт цувралаар зохион байгуулж байна.



Хүүхэд, залуучуудын паркийг 110.0 сая төгрөгөөр барьж байна.



Хөл бөмбөгийн талбайг ашиглалтанд хүлээн авснаар хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна.



Занабазарын сэрэг дүр бүхий цэнгэлдэх хүрээлэнг 239 сая төгрөгөөр шинээр бий болгов.

2. АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙ УГТСАН 80 БҮТЭЭЛЧ АЖЛЫГ ӨРНҮҮЛЖ, АЙМГИЙНХАА НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨРХИЙГ САЙЖРУУЛАВ.

Өвөрхангай аймаг байгуулагдсаны 80 жилийн ой угтсан 80 бүтээлч ажлыг эхлүүлж Нутгийн удирдлагын танхимд “Сүлд танхим”-ыг иж бүрнээр байгуулж, Аюуш баатрын талбайг боржин хавтангаар бүрж, 105 багийн Засаг дарга нарыг бүрэн унаажуулан, аймаг анх байгуулагдсан Баянхонгор аймгийн Түйн голын Цагаан эрэгт босгосон дурсгалын хөшөөний орчныг тохижуулав.



Баянхонгор аймгийн Түйн голд аймаг анх үүссэн газрыг тохижуулав.



Аюуш баатрын төв талбайг боржин чулуугаар бүрж, Нутгийн удирдлагын ордныг 84 сая төгрөгөөр засварлав.



Сүлд танхимыг шинээр 40 гаруй сая төгрөгөөр тохижуулав.

3. АЙМАГ 2010 ОНЫГ “ОРЧНОО ТОХИЖУУЛАХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАЖ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫГ САЙЖРУУЛАВ.



Уянга сумын “Бизнес хөгжлийн төв”-ийг шинээр бий болгов

Аймгийн ИТХ-аас 2010 оныг “Орчноо тохижуулах жил” болгон тусгай болзол зарлаж дүгнэв.

Сумдаас Уянга, Баянгол, Арвайхээр, байгууллагуудаас аймгийн Онцгой байдлын газар, өрхөөс Баянгол сумын иргэн Ш.Халтар нар шалгарч орчны тохижилт дээшилж байна.

Орчны тохижилтын жилд 9142.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, 5543 м2 талбай шинээр хийж,

1497.5 метр явган хүний зам тавьж, 87.2 сая төгрөгийн гэрэл шинээр нийтийн эзэмшлийн талбайд суурьлуулан, 53755 ширхэг мод бут тарьж, 10 сум 744.6 сая төгрөгийн хөрөнгөөр цэцэрлэгт хүрээлэн байгуулан, 133 ширхэг хогийн савыг нийтийн эзэмшлийн зам талбайд шинээр байрлуулан, 177 байгууллага гадна өнгө үзэмжээ сайжруулсан байна.



Орчны тохижилтоороо шалгарсан өрх Баянгол сумын Ш.Халтарын гэр бүл бусдадаа үлгэр дууриал үзүүлж байна.



Баянгол сум тохижилтоороо шалгарч цэцэрлэгт хүрээлэн, зам засвар, нийтийн биеийн тамирын талбайг шинээр байгуулав.

4. МОНГОЛ АЙЛ ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛУУЛЖ, ХҮНИЙ ХӨГЖИЛ, АМЬДРАЛЫН ЧАНАРТ ШИНЭЧЛЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ГАРГАВ.



Гэр бүл хүний хөгжлийн төвийг ашиглалтанд оруулж хурим, сургалт, тэмдэглэлт өдрийг зохион байгуулж байна.

Арвайхээр хотод “Гэр бүл хүний хөгжлийн төв буюу Гэрлэх ёслолын ордонг шинээр ашиглалтанд оруулж, “Гэр бүл төлөвлөлт”, “Хүний хөгжил”, “Гэр бүл дахь хүүхдийн хүмүүжил” зэрэг сэдвүүдээр сургалт, “Гэр бүлийн өдөр”, залуу гэр бүл, олон жил хамтран амьдарсан гэр бүлүүдийн ёслол, хүүхдийн даахь үргээх ёслол, төрсөн өдөр болон тэмдэглэлт баярын өдрүүдийг зохион байгуулж байна.

Мөн улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 12, 20, 25, 40, 60

айлын орчин үеийн тохилог орон сууцуудыг ашиглалтанд оруулж, аймаг, сумдын төвд иргэд амины тохилог орон сууц олноор барьж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлж байна.




Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэж, 21 тэнгэрлэг гэр бүлгийг шалгаруулав.



Шинээр баригдсан орон сууцны хороолол

5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАВ.



Аймгийн албан ёсны цахим хуудсыг тогтмол шинэчлэн ажилладаг.

Аймгийн хэмжээнд мэдээлэл, технологийг хөгжүүлэх ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн албан ёсны цахим хуудас, Арвайхээр суманд мэдээллийн урсдаг самбар, Арвайхээр, Гучин-Ус сумд, хууль хяналтын байгууллага, Боловсрол соёлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүүхдийн төлөө хэлтэс, БОЭТөв, Хөгжимт драмын театр зэрэг албан байгууллагууд шинээр цахим хуудастай болж, 8 сумд шилэн кабель, модем ашиглан цаг үеийн мэдээ, тайланг интернетийн сүлжээ ашиглан шууд дамжуулж, төрийн үйлчилгээний хүртээмж, мэдээллийн чанарыг

хэвшээд байна.



Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын цахим хуудас



Хөгжимт Драммын Театрын цахим хуудас

6. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 143 ДУГААР ТОГТООЛЫГ БҮХ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АЖИЛЛАСНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ ДЭЭШИЛСЭН.



А. Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг улсын хэмжээнд ил тод, нээлттэй хэлбэрээр өндөр түвшинд зохион байгуулж хэвшлээ.

Төрийн албаны сонгон шалгаруулалт харьцуулсан график

Б. Байгууллагын ил тод байдлыг сайжруулахад анхаарч аймаг, сум, багт төрийн байгууллагын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулан тайлан тавьж, үйл ажиллагаа, үр дүнг хэвлэл, мэдээллээр өргөн сурталчлан, аймаг, сумын ЗДТГ, төрийн бүх байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ хийх, “Нээлттэй хаалга”-ны өдрийг зохион байгуулах үеэр иргэдээр



Бүх байгууллагууд иргэдэд нээлттэй байдлаар тайлагнадаг.

хэрэглэгчдийн үнэлгээ өгүүлж хэвшээд байна.

В. Төрийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах чиглэлээр төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагууд хамтран гурван талт түншлэлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төрийн бараа, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой ажлын хэсэг хяналт тавих ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

9. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ХҮРЭЭНД ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРҮҮД НЭМЭГДЭЖ, 2537 АЖЛЫН БАЙР ШИНЭЭР БИЙ БОЛЛОО.



Монгол Улсын Засгийн газраас “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласны хүрээнд аймгийн эдийн засгийн гол тулгуур болох мал аж ахуй, хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд нэгдсэн бодлого зохицуулалтаар ханган ажиллаж, ЖДҮДС-аас өнгөрөгч онд 627.6 сая төгрөгийн санхүүжилтээр 39 жижиг дунд үйлдвэр байгуулагдаж, 852.9 сая төгрөгийн санхүүжилтын хөрөнгөөр эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэн, 2537 ажлын байр шинээр бий болсон байна.

Орон нутагтаа үйлдвэрлэж буй шинэ бүтээгдэхүүн, шинэ брендийн нэр төрөл нэмэгдсээр байна.



Жил бүр “Өвөрхангай түншлэл”-ийг намрын налгар өдрүүдэд бүсийн хэмжээнд зохион байгуулдаг уламжлалтай.



2010 онд 14 үнээ, тахианы ферм шинээр нэмэгдлээ.



Мөнгөн мод ХК-ийн гэрийн мод нутгийн бренд болж, гадаад зах зээлд их эрэлттэй байна.

10. ИРГЭДЭД НЭГ ЦЭГЭЭС ОЛОН ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛДЭГ.

Төрийн үйлчилгээг нэг дороос иргэдэд хүргэх зорилгоор Арвайхээр, Хархорин сумдад “Нэг цонхны үйлчилгээний төв”-ийг шинээр байгуулж, 87.4 сая төгрөгийн өртгөөр бүрэн тохижуулан төрийн анхан шатны үйлчилгээ болох иргэний бүртгэл, газар, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, банкны салбар, нотариатын үйлчилгээг өнгөрөгч онд 13000 гаруй үйлчлүүлэгчдэд чанартай, шуурхай хүргээд байна.



Нэг цэгээс төрийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР